32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	917,757,500.00	808,172,622.61	805,427,909.69
320001	Орон нутгийн төсвөөс	917,757,500.00	808,172,622.61	805,427,909.69
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	174,773,000.00	30,806,600.00	-30,119,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,255,500.00	30,749,000.00	-30,434,000.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	57,600.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	151,517,500.00	0	-821,097.20
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	158,771,667.66	158,771,667.66
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	249,582,944.20	249,582,944.20
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	92	96	96
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	4
610001	Төсвийн байгууллага	4	4	4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	46	46
620001	Удирдах ажилтан	6	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	9	10	10
620003	Үйлчлэх ажилтан	26	26	26
620004	Гэрээт ажилтан	3	3	3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44	46	46
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26	26	26
650010	Гэрээт ажилтан	3	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,132,214.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,132,214.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	109,972,209.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,990,679.00
210301	Гэрэл, цахилгаан	1,025,379.00
210303	Цэвэр, бохир ус	5,965,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,138,140.00
210402	Тээвэр, шатахуун	8,098,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,915,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,800,000.00
210602	Тавилга	1,500,000.00
210604	Урсгал засвар	12,615,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,820,000.00
210702	Дотоод албан томилолт	1,820,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,958,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,958,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,149,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,849,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,160,005.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,999,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,999,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,160,605.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	333,066.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,827,539.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,799,148.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,799,148.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	113,999,148.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-333,066.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	333,066.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын нь “Сум орон нутгийн хөгжил дэвшлийг хангаж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэн бүрд ил тод, жигд хүртээмжтэй хүргэх” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,301.8 сая төгрөгөөр буюу 53 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	391.3	530.2	138.9
Авлага	136.4	55.0	-81.4
Бараа материал	253.2	118.3	-134.9
Үндсэн хөрөнгө	2,012.3	787.9	-1,224.4
Нийт хөрөнгө	2,793.2	1,491.4	-1,301.8
Өр төлбөр	6.4	15.5	9.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,786.8	1,475.9	-1,310.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,793.2	1,491.4	-1,301.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийг үлдэгдэл өссөн нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөгдөөгүй 128.1 сая төгрөгийн орлого орсон нь нөлөөлсөн байна.
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 134.9 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн, мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 29.7 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж дээд шатны төсөв захирагчид нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатны төсөв захирагчид нэгтгүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 530.2 сая төгрөг болж, өмнөх оноос 139.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	2.8	2.9	0.0
Банканд байгаа бэлэн мөнгө	0.013	0.038	0.025
Төрийн сангийн харилцах нэмэлт санхүүжилтийн харилцах	388.1	527.3	139.2
Дүн	391.3	530.2	139.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 530.2 сая төгрөгийн 527.3 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 2.9 сая төгрөг нь байгууллагын /ЭЭС/ кассад байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 163.4 сая төгрөг буюу 30.1 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 86.2 сая төгрөг буюу 16.2 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 277.7 сая төгрөг буюу 52.3 хувь төрийн сангийн харилцахын оны эхний зарцуулагдаагүй үлдэгдэл тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- Ажил гүйцэтгэх гэрээнд техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ нарийвчлан тусгагдаагүй зөрчилд зөвлөмж өгсөн.
- Ахуй үйлчилгээний төвийн тохижилт, сантехникийн холболтын ажлын санхүүжилтийг 100 хувь олгосон боловч дуусаагүй, ажил хүлээн аваагүй,
- Төлбөрийн цахим системд 5 төсөл, арга хэмжээний нийт 136.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээний төлбөрийн ebarimt шивээгдээгүй,
- Магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй 169.4 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зэрэг зөрчилүүдэд албан шаардлага хүргүүлсэн. /ОНХС/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 55.0 сая төгрөг болж, өмнөх оноос 31.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Дансны авлага /ТӨҮГ/	0.00	0.81	0.8
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	0.00	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	50.11	0.00	
Байгууллагаас авах авлага	2.43	0.00	-2.4
Хувь хүмүүсээс авах авлага	83.89	54.22	-29.7
Дүн	136.4	55.0	-31.3

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 49.2 сая, Молцог илч ОНӨААТҮГ-ын 0.8 сая, хувь хүнээс авах авлага 5.0 сая төгрөг байна. Авлагын дансны үлдэгдлийн 89.5% нь хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 118.3 сая төгрөг болж, өмнөх оноос 134.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	0.41	0.00	- 0.4
Эм боох материал	43.38	22.58	-20.8
Бичиг хэргийн материал	3.07	0.67	- 2.4
Аж ахуйн материал	120.26	37.27	-83.0
Сэлбэг хэрэгсэл	13.14	0.00	- 13.1
Түлш тослох материал	2.89	0.00	-2.9
Хүнсний материал	4.02	0.00	-4.0
Бусад хангамжийн материал	25.90	0.00	-25.9
Мал амьтад	40.14	57.82	17.7
Дүн	253.2	118.3	- 134.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 118.3 сая төгрөгийн үлдэгдлийн 49 хувийг мал амьтад эзэлж байгаа бөгөөд аж ахуйн материал, эм боох материалын үлдэгдэл гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн аж ахуйн материалын 90 хувийн Засаг даргын Тамгын газар, 1.1 хувийг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 8.9 хувийг Молцог илч ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд эзэлж байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 562.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2,327.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	1,620.7	162.0	-1,458.7
Тээврийн хэрэгсэл	281.0	187.5	-93.5
Машин тоног төхөөрөмж	285.3	50.8	-234.5
Тавилга эд хогшил	153.5	59.1	-94.4
Дуусаагүй барилга байгууламж	-	94.8	94.8
Номын фонд	11.0	-	- 11.0
Бусад үндсэн хөрөнгө	508.1	0.6	-507.5
Программ хангамж	2.5	5.7	3.2
Бусад биет бус хөрөнгө	27.4	1.7	-25.8
Дүн	2,889.5	562.1	-2,327.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 30.8 сая, үнэ төлбөргүй 185.4 сая, шилжүүлэн авсан 98.2 сая, нийт 314.5 сая төгрөгөөр нэмэгдэж, Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатын төсөв захирагчид шилжүүлсэн 1,920.7

сая, мөн шилжүүлсэн 129.8 сая, акталж данснаас хассан 13.7 сая, нийт 2,064.3 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 15.6 сая төгрөг болж, өмнөх оноос 6.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	-	-	-
<i>Байгууллага төлөх өглөг</i>	6.4	0.0	-6.4
<i>Хувь хүмүүст төлөх өглөг</i>	0.1	0.0	-0.1
<i>Дансны өглөг</i>	0.0	15.6	15.6
Нийт дүн	6.4	15.6	-6.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 15.0 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь Молцог илч ОНӨААТҮГ-ын үүссэн өр төлбөр байна.

Аудитын илрүүлэлт:

- Нөөцийн өвс 4000 боодол бэлтгэх ажлыг жижиглэн 2 хуваасан, 2021 онд өвсөө авахдаа данс бүртгэлд тусгаагүй, өр авлага үүсгээгүй
- 2021 онд 800 шуудай Малын тэжээл бэлтгэхдээ данс бүртгэлд тусгаагүй, өр авлага үүсгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. /ОНХС/

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,475.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,310.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/
<i>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</i>	1,642.1	251.2	-1,390.9
<i>Өмнөх үеийн үр дүн</i>	682.4	2,425.3	1,742.9
<i>Тайлант үеийн үр дүн</i>	298.3	-1,257.2	- 1,555.5
<i>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</i>	164.0	56.6	-107.4
Дүн	2,786.8	1,475.9	-1,310.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгийн дүн 1,475.9 сая төгрөг болж 1,310.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн байгууллага бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлж, дээд шатны төсөв захирагчид нэгтгүүлснээс засгийн газрын оруулсан капитал 1,390.9 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 107.4 сая, хуримтлагдсан үр дүн 219.9 сая нийт 1,718.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын залруулга хийж тайлант үед 1,257.2 сая төгрөгийн үр дүнгүй ажилласан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 182.4 сая төгрөг, татварын бус орлого 8.0 сая нийт 190.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр татварын орлого 340.2 сая, татварын бус орлого 4.8 сая нийт 344.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын гүйцэтгэл 181 хувиар давсан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО	190.4	344.9
ТАТВАРЫН ОРЛОГО	182.4	340.2
Хувь хүний орлогын албан татвар	96.5	143.4
ЦХХТАОСАТ	60.0	100.5
Үйл ажиллагааны орлого	15.0	11.2
Хөрөнгө борлуулсны орлого	3.5	-
Хөрөнгийн орлого	18.0	25.5
Шууд бус орлого	-	6.2
Хөрөнгийн албан татвар	82.3	67.4
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2.5	4.2
Бууны албан татвар	0.8	1.0
Малд ногдуулах албан татвар	79.0	62.2
Бусад татвар (төлбөр, хураамж)	3.0	0.7
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	0.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	0.5	-
Газрын төлбөр	0.5	0.4
Газрын төлбөр	0.5	0.4
Байгалийн нөөц ашигласний төлбөр	0.2	128.3
Ан амьтний нөөц ашигласны төлбөр	-	128.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.2	0.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8.0	4.8
Хүү, торгуулийн орлого	8.0	4.8

Орон нутгийн татварын болон татварын бус орлого төлөвлөснөөс 154.5 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгдөөгүй ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого орсон нь нөлөөлсөн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,277.6 сая төгрөг, нийт зардлыг 1,277.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Наран сумын 2022 оны нэгтгэсэн төсвийг тайлант оны давсан орлого болон Төрийн үйлчилгээний албан хаагчдын ТҮ1-4 шатлалын хоорондох цалинг улсын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 6 дугаар сарын 03 өдрийн №5 тогтоолоор нийт зардлыг 1,173.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1,374.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,069.2 сая төгрөгийг урсгал төсвөөс, 281.8 сая төгрөгийг орон нутгийн

хөгжлийн сангаас, 23.3 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас зээл, зээлийн хүүгийн орлогоос санхүүжүүлэхээр батлагджээ.

Гүйцэтгэлээр хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 30.7 сая, орон нутгийн төсвөөс 808.2 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 247.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.05 сая нийт 1,086.5 сая төгрөгийг санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 988.5 сая төгрөг буюу 91 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	/сая төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	82.2	64.9	17.3	79%
2	80224- Зөвлөл, хороо, комиссын гишүүд	7.5	7.5	0.0	100%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	7.1	7.1	0.0	100%
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	3.0	3.0	0.0	100%
5	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	4.0	2.7	1.3	67%
Дүн		103.8	85.2	18.6	
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	304.0	264.9	39.1	87%
2	80106- Баг хорооны үндсэн үйл ажиллагаа	35.7	31.6	4.2	88%
3	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	5.7	5.7	0.0	100%
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	13.0	13.0	0.0	100%
5	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	5.0	4.9	0.1	99%
6	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	50.0	49.9	0.1	100%
7	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	6.0	5.9	0.1	99%
8	82706-Гоц халдварт өвчний голомтыг арилгах	4.0	4.0	0.0	100%
9	туслах үйл ажиллагааны орлого	0.0	0.1		
Дүн		423.4	380.0	43.5	
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	37.1	10.4	26.7	28%
2	83201-Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээ	5.3	4.5	0.8	85%
Дүн		42.4	14.8	27.5	
71802 ерөнхий боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	57.3	52.7	4.6	92%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	31.3	31.3	0.0	100%
Дүн		88.65	84.03	4.62	
71702 соёл урлаг					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	60.5	28.0	32.5	46.2%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	2.8	2.8	0.0	100.0%
3	83201-Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээ	4.5	4.5	0.0	100.0%
Дүн		67.8	35.2	32.5	52.0%
Орон нутгийн хөгжлийн сан хөтөлбөр бичих					
2	83401-Итгэлцүүрээр	222.5	171.4	51.1	77.02%
3	83402-Хайгуулын тусгай зөвшөөрөл	33.6	25.0	8.6	74.51%
4	83405-Малын тоо толгойн албан татвар	79.0	51.7	27.3	65.44%

5	83406-ОНХС-бусад	106.3	95.7	10.7	89.97%
Дүн		441.5	343.8	97.7	77.88%
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих					
1	82611-Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих	1.0	0.3	0.7	30.0%
2	83111-Сум хөгжүүлэх	155.5	0.0	155.5	0.0%
Дүн		156.5	0.3	156.2	0.2%
71801 сургуулийн өмнөх боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	24.5	19.3	5.24	78.6%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	13.9	13.9	0.00	100.0%
3	83201-Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээ	11.9	11.9	0.00	100.0%
Дүн		50.3	45.1	5.2	89.6%
Нийт дүн		1,374.3	988.5	385.8	71.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 114.0 сая нийт 118.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд 7.0 сая, хангамж, бараа материалын зардалд 9.1 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 24.9 сая, дотоод албан томилолт 1.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 54.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 13.1 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 7.0 сая, нийт 116.9 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 2.2 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Наран сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дотоод хяналт, цалин хөлстэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2023 оны 3 дугаар сарын 15 -аас 2023 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 1,822.0 сая төгрөгийн зардлын 2 хувь буюу 36.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Наран сумын Засаг даргын тухай хуульд хамаарах зүйл заалт бүрээр горим сорил хэрэгжүүлсэн. Наран сумын Засаг даргын Тамгын газар албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдад хоол хүнсний материал худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 1.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Наран сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 16.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1.1 Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 16.8 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	1	1.1	1	1.1	-	-	-	-	-	-	-	-
Молцог илч ОНӨААТҮГ	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-
ОНХС	6	436.0	-	-	5	436.0	1	-	-	-	-	-
Дүн	9	437.1	1	1.1	5	436.0	3	-	-	-	-	-